



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч: Батлан хамгаалах яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)
----------------	--

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Эрдэнэбилэг	Хуульч, судлаач
---------------	-----------------

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	
УДИРТГАЛ	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
2.1. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог, түүний хууль зүйн учир холбогдол	
2.2. Цэргийн алба хаагчийн холбогдсон эрх зүйн зөрчлийн шинж, хүлээлгэсэн хариуцлагын өнөөгийн байдал	
2.2.1. ЦАХ-ийн гэмт хэрэг, сахилгын зөрчлийн статистик, түүний шалтгаан нөхцөл	
2.2.2. ЦАХ-ийн эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	
2.3. ЦАХЭЗБТ хуультай холбогдуулан гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд	
	19
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	21
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	21
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	22
3.3 “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	26
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	29
ТАВ. САНАЛ	31
ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	33
ДОЛОО. ХАВСРАЛТУУД	36-46
№ 1 ЦАХ-ийн ажилласан хугацааг өсгөх зохицуулалтууд	36-37
№2 ЦАХ-ийн ажиллах насны дээд хязгаар	
№ 3 Цэргийн албаны тухай хуулийн бүтэц	
№4 ЦАХ-ийн эрхийг баталгаажуулсан хуулиудын холбогдох зүйл заалтуудын харьцуулалт	
№ 5 ЦАХ-ийн албан үүрэг гүйцэтгэх бусад баталгааг баталгаажуулсан хуулиудын холбогдох зүйл, заалтуудын харьцуулалт	
№ 6 ЦАХ-ийн үүргийг баталгаажуулсан хуулиудын холбогдох зүйл, заалтуудын харьцуулалт	
№7 ЦАХ-ийн эрхийн хязгаарлалтыг баталгаажуулсан хуулиудын холбогдох зүйл заалтуудын харьцуулалт	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
ЦАХЭБТ хууль	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
Монгол Улсын БХТ хууль	Монгол Улсын Батлан хамгаалахын тухай хууль
Монгол Улсын Хилийн тухай хууль	Монгол Улсын Хилийн тухай хууль
ЦАХТТТ хууль	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
ТАТ хууль	Төрийн албаны тухай хууль
ЦАТ хууль	Цэргийн албаны тухай хууль
ГХТ хууль	Гамшгаас хамгаалах тухай хууль
ДЦТ хууль	Дотоодын цэргийн тухай хууль
ГХТ хууль	Гамшгаас хамгаалах тухай хууль
ЭДАОТ хууль	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль
НАНБХАСЗАСЗУСТ хууль	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
БХЯ	Батлан хамгаалах яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн

УДИРТГАЛ

1992 оны Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд цаг үеийн шаардлагаар 15 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.2.2,-т “...зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ”, 4.1.4-т “Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ”, Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг хангана” гэж тус тус заасны дагуу батлан хамгаалахын хууль тогтоомжийг шинэчлэн, батлан хамгаалах бодлогын тулгуур бичигтэй нийцүүлэн Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэтгэн Цэргийн албаны тухай болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг баталжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчаас санаачилсан 2016 оны Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдан гарсан бусад салбарын хууль тогтоомжтой нийцүүлэн тус хуулийн зорилт, хамрах хүрээ, үйлчлэлийг зөв зохистой хэрэгжүүлэх, цэргийн жинхэнэ алба хаагчийн эрх зүйн байдлыг иргэний цэргийн үүргээс тусад зааглаж цэргийн алба хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг дээшлүүлэх, үүрэг хариуцлага, хязгаарлалтыг шинээр тодорхойлжээ.

Цэргийн алба хаагч гадаад улсад энхийг дэмжих ажиллагаанд оролцох, ангийн байрлалаас гадна бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох болон хуульд заасан бусад үүрэг гүйцэтгэх тохиолдол бүрийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох зохицуулалтыг хуульд тусгасан нь онцлог байна.

Иймд Улсын Их Хурлын “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан ЦАХЭЗБТ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсруулан¹ хүргүүлж байна.

¹ Судалгааг 2021.09.13-ны өдрөөс 2021.09.27-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль /цаашид “ЦАХЭЗБТ хууль” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажил хийгдэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

2016 оноос хэрэгжсэн ЦАХЭЗБТ хуулийн үзэл баримтлал, 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн энэхүү хуульд орсон зарим өөрчлөлт, шинэчлэгдсэн Төрийн албаны хууль тогтоомжийн уялдаа холбоо болон амьдралд хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, өөр хоорондоо зөрчилтэй зохицуулалт үүссэн эсэхийг тодорхойлох зорилгоор хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэн энэхүү судалгааг хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /эерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа учраас Төрийн албаны тухай, Цэргийн албаны тухай хуулиуд болон ЦАХЭЗБТ хуулийн уялдаа холбоо, хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох явцад гарч буй тулгамдсан асуудлыг тодорхойлоход энэхүү хуулийн 1, 4, 7 дугаар зүйлүүдийг сонгон үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойллоо.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХЭЗБТ хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтооход оршино.” гэж заасныг удирдлага болгон ЦАХЭЗБТ хууль батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг шалган хууль бүхэлдээ зорилго, зорилтдоо нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйлтэй харьцуулан онцлогыг тодорхойлон зорилгодоо хүрч байгаа эсэхийг судлахаар сонгож авлаа.

Мөн хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй алдаа дутагдал, эерэг болон сөрөг байдал, тулгамдсан асуудлыг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд ЦАХЭЗБТ хуулийн 4 дүгээр зүйл /Хуулийн үйлчлэх хүрээ/-ийн 4.3.9, 7 дугаар зүйл /Цэргийн алба хаагчийн давуу эрх/-ийн 7.1.14 дэх, 8 дугаар зүйл /Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт/-ийн 8.1.7 дахь заалтууд болон энэхүү хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр өөрчлөлт оруулахдаа хуулийн 7 дугаар зүйл /Цэргийн алба

хаагчийн давуу эрх/-ийн 7.1.7, 7.1.17, 7.1.21 дэх заалтыг хүчингүй болгож, мөн зүйлийн 7.1.1, 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйл /Цэргийн алба хаагчийн цалин хөлс/-ийн 9.5 дахь хэсэгт заасан хуулийн зохицуулалтад орсон өөрчлөлтийг сонгосон юм.

Хүснэгт 1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	1 дүгээр зүйл /Хуулийн зорилт/-ийн 1 дэх хэсэг	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтооход оршино

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	4.3. Энэ зүйлийн 4.2-т зааснаас гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно: “4.3.9. энхийг дэмжих ажиллагаанд оролцох;”
2	7 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн давуу эрх	7.1.Цэргийн алба хаагч дараахь давуу эрхийг эдэлнэ: 7.1.14.офицер, ахлагч шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүнийг гэр бүлийн гишүүд, ачаа тээшний хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн хэрэгслийг анги, байгууллагаас гаргах буюу зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож олгох;
3	8 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт	8.1. Цэргийн алба хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 8.1.7. хуулийн дагуу нууцын зэрэгт хамаарах баримт бичиг, зэвсэг, техник хэрэгсэлтэй ажиллаж байсан цэргийн алба хаагч цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа гурван жилийн дотор гадаад улсад байнга оршин суухаар явах;
4	ЦАХЭЗБТ хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр өөрчлөлт оруулахдаа хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.17, 7.1.21 дэх заалтыг хүчингүй болгож, мөн зүйлийн 7.1.1, 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан хуулийн зохицуулалтад орсон өөрчлөлт	

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.

3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх буюу хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулан ашиглав.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно.

Судалгааны эх сурвалжаар зэвсэгт хүчин, онцгой байдал, хил, дотоодын цэргийн алба хаагчдын эрх зүйн байдал, үйл ажиллагааны хязгаарлалттай холбоотой харилцааг зохицуулсан хуулиуд, захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд болон цэргийн албаны мэдээлэл, бодлого зохицуулалтын болон хуулийн асуудал хариуцсан алба хаагчидтай социологийн ярилцлага түүнчлэн цахим мэдээллийн санд байршуулсан мэдээлэл, сургалт түүнд хандалт хийсэн иргэдийн сэтгэгдлийг үнэлгээнд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

2.1. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог, мөн чанар, хууль зүйн учир холбогдол

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”, 2 дахь хэсэг “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж хуульчлан баталгаажуулсан.

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.6 дахь заалтаар “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, ... байгууллагын удирдлага, офицер, ахлагч, ... хамаарна” гэж заасан.

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар цэргийн албанд “зэвсэгт хүчин², хилийн³ ба дотоодын цэрэг⁴, онцгой байдлын байгууллага⁵-д

² 2016.09.01-ний Зэвсэгт хүчний тухай хууль. Төрийн мэдээлэл №36

³ 2016.12.28-ны Монгол Улсын хилийн тухай хууль 2017.02.01-ноос Төрийн мэдээлэл №6, 2017

⁴ 2017.02.01-ний Дотоодын цэргийн тухай хууль 2017.09.01-нд мөрдөгдсөн. Төрийн мэдээлэл №12, 2017

⁵ 2017.02.02-ны Гамшгаас хамгаалах тухай хууль 2017.02.27-ноос Төрийн мэдээлэл №7, 2017

Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхаар тодорхойлжээ.

Цэргийн алба хаагчид нь цэргийн жинхэнэ албыг хааснаар Үндсэн хуульд заасан түр буюу байнга оршин суух газраа сонгох, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг олон эрхүүдэд хязгаарлалт тогтдог төдийгүй шаардлага гарвал эх орныхоо төлөө амьд явах эрхээсээ татгалзахаа илэрхийлж тангараг өргөдөг төрийн тусгай алба хаагч мөн.

2.1.1. Цэргийн алба хаагчийн нийтлэг эрх ЦАХЭЗБТ болон холбогдох хуульд тусгагдсан нь

Цэргийн алба хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрхийг эдлэхээс гадна ЦАХЭЗБТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт түүний нийтлэг эрхийг хуульчилжээ.⁶

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт Онцгой байдлын байгууллагын алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ЦАХЭЗБТ хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна эдлэх эрхийг баталгаажуулсан байна.

Түүнчлэн Дотоодын цэргийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт дотоодын цэргийн алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ЦАХЭЗБТ хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна эдлэх эрхийг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “хилийн цэргийн алба хаагчийн алба хаах, тэдгээрийн эрх зүйн байдлыг Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуулиар зохицуулна.” гэж заажээ.

2.1.2. Цэргийн алба хаагчийн давуу эрх ЦАХЭЗБТ болон холбогдох хуульд тусгагдсан нь

ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт цэргийн алба хаагчийн давуу эрхийг Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэний эрх зүйн баталгааг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааг, Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлд дотоодын цэргийн алба хаагчийн чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг тус тус хуульчилсан байна.⁷

2.1.3. Цэргийн алба хаагчийн нийтлэг үүрэг ЦАХЭЗБТ болон холбогдох хуульд тусгагдсан нь

Цэргийн алба хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хүлээхээс гадна ЦАХЭЗБТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт тэдгээрийн нийтлэг үүргийг хуульчилжээ.⁸

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 48 дугаар зүйлд онцгой байдлын байгууллагын алба хаагч, Дотоодын цэргийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд ЦАХЭЗБТ хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна хүлээх үүргийг тусгайлан хуульчилсан байна.

2.1.4. Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт ЦАХЭЗБТ болон холбогдох хуульд тусгагдсан нь

⁶ Хавсралт №4 харьцуулалтуудыг үзнэ үү.

⁷ Хавсралт №5 харьцуулалтуудыг үзнэ үү.

⁸ Хавсралт №6 харьцуулалтуудыг үзнэ үү.

Цэргийн албан хаагчид Төрийн албаны тухай 39 дүгээр зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, ЦАХЭЗБТ хуулийн 8 дугаар зүйлд заасан цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /цаашид НАНБХАСЗАСЗУСТ хууль гэх/-ийн 10-22 дугаар зүйлд заасан хязгаарлалтууд үйлчилж байна.⁹

Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдал нь Төрийн албаны тухай хууль, ЦАХЭЗБТ хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, НАНБХАСЗАСЗУСТ хуульд заасан эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй билээ. Үүнд:

- Батлан хамгаалахын тухай хууль
- Зэвсэгт хүчний тухай хууль
- Цэргийн албаны тухай хууль
- Дайчилгааны тухай хууль
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль
- Цэргийн алба, алба хаагчидтай холбоотой бусад хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд

Энэ ч утгаар 2016 оны ЦАХЭЗБТ хуулийн үзэл баримтлал, бүтцийн 6 бүлэг 11 зүйлийн хувьд нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тооцох нь зүйтэй гэж үзлээ.¹⁰ Үүнд:

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль	
Нэгдүгээр бүлэг.	Нийтлэг үндэслэл
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	
2 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж	
3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын зарчим	
4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ	
Хоёрдугаар бүлэг.	Цэргийн алба хаагчийн эрх, үүрэг
5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрх	
6 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн үүрэг	
Гуравдугаар бүлэг.	ЦАХ-ийн давуу эрх, эрхийн хязгаарлалт
7 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн давуу эрх	
8 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт	
Дөрөвдүгээр бүлэг.	ЦАХ-ийн цалин хөлс, шагнал урамшуулал
9 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн цалин хөлс	
Тавдугаар бүлэг.	Галт зэвсэг хэрэглэх
10 дугаар зүйл. Цэргийн алба хаагч галт зэвсэг хэрэглэх	
Зургадугаар бүлэг,	Бусад зүйл
11 дүгээр зүйл. Хүлээлгэх хариуцлага	

Тухайлбал, Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйл /Зэвсэгт хүчний чиг үүрэг/-ийн 6.2.11 дэх заалт “бүтээн байгуулалтын ажилд оролцох;” чиг үүргийг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан төдийгүй энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.” гэж заасан байна.

⁹ Хавсралт №7-гоос үзнэ үү.

¹⁰ Хавсралт №3 ээс Цэргийн албаны тухай хуулийн бүтцийг үзнэ үү.

“Зэвсэгт хүчний хуульд улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад Монгол Улсын Зэвсэгт хүчин оролцох шинэ үүргийг тодорхойлсон байна.

Энэхүү үүргийн хувьд “..... Өнгөрсөн хугацаанд Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний ордын төмөр бетон гүүр, Дорнод аймгийн Халх гол сумын шинэ бүтээн байгуулалт, газрын тосны үйлдвэрийн хүнд даацын авто зам, Зүүнбаян Тавантолгой чиглэлийн төмөр замын доод суурь, дэд бүтцийн ажил, тус төмөр замыг дагасан дэд бүтэц буюу нэг өртөө, зургаан зөрлөгийн барилгын ажлыг Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчид богино хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэлээ. Өнөөдөр газрын тосны үйлдвэрийн дэд бүтэц буюу орон сууцны хорооллуудыг барих ажлыг Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн хийж байна.....

Зэвсэгт хүчний зарим анги, салбарыг орчин үеийн хэв маягийг харуулсан инженерийн шинэлэг шийдэл бүхий “Жишиг цэргийн хотхон” болгох зорилтыгЗасгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулж батлуулаад байна. Мөн “Жишиг цэргийн хотхон” төслийн зураг, төсөл, тооцоо, судалгаа бүрэн хийгдсэн.”¹¹ байна.

2.2. Цэргийн алба хаагчийн холбогдсон гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн өнөөгийн байдал, ¹²

2.2.1. Гэмт хэрэг, сахилгын зөрчлийн статистик, түүний шалтгаан нөхцөл

ЦАХЭЗБТ хуулийн зорилт нь Монгол Улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтооход орших бөгөөд энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагавар нь цэргийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, бусад төрлийн зөрчил түүнд хүлээлгэсэн хариуцлагаар илэрхийлэгдэнэ.

Иймд Зэвсэгт хүчинд 2011-2020 онд бүртгэгдсэн гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, тархалтыг тодорхойлж, гэмт хэргийн улмаас үүссэн хор хохирлыг тодорхойлон гаргаж, дүн шинжилгээ хийгдсэн байх бөгөөд батлан хамгаалах тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 оноос хойш буурах үзүүлэлт гарчээ.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 54, жилд дунджаар 5 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт гэмт хэрэгт 78 цэргийн алба хаагч холбогдон шалгагдсан статистик мэдээ байна.¹³

№	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	2	2	1	4	2	2	5	5	18	13	54
2	Өсөлт, бууралт /хувиар/	33,3	0	-50	400	-50	0	250	0	360	-27.7	
3	Холбогдсон хүний тоо	3	2	1	4	4	2	5	7	20	17	65
4	Өсөлт, бууралт /хувиар/	0	33,3	-50	400	0	-50	250	40	285	-15	

¹¹ БХЯ-ны цахим сайтад тавигдсан Батлан хамгаалахын Сайдын мэдээллээс.....

¹² УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан "Батлан хамгаалах салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл болон хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар" тавьсан асуулгын хариу

¹³ Энэхүү статистикт хил, дотоодын цэрэг болон Онцгой байдлын алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг тусгагдаагүй гагцхүү зэвсэгт хүчний салбарт гэснийг дахин тодотгох нь зүйтэй байна.

2000 оноос өмнө Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг Цэргийн хэрэг бүртгэх алба хэрэгжүүлж байгаад татан буугдсан билээ.

Зэвсэгт хүчинд бүртгэгдээгүй өөрөөр хэлбэл, цэргийн алба хаагч цэргийн анги, байрлалаас гадна нийгмийн харилцаанд иргэний хувьд оролцож байхдаа үйлдсэн гэмт хэргүүд прокурор, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгддэг онцлогоос хамаарч дүн бүртгэл зөрүүтэй гарах нөхцөл болсон байна.

Иймд 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гарган ажиллажээ.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 2011-2020 онд 12 төрлийн 78 холбогдогчтой 54 эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдэж, шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнд:

Гэмт хэргийн төрөл	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Анги, байрлалаа орхин оргон зайлсан	1	1								1
Хүний амь нас хохирсон	1		1		2				1	
Галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбоотой		1				1				
Бусдын бие махбодод гэмтэл учруулсан				4		1	2	2	2	4
Амиа хорлохыг завдсан							3			
Албан тушаалаа урвуулан								1	1	
АТХХАБАЖ зөрчсөн								2	3	3
Хүчиндэх									3	
Дээрэм									1	
Хууль бус ан агнах									3	
Хулгай									2	4
Цэргийн албаны эсрэг									2	1

Дээрх гэмт хэргүүдийн 5.5 хувь нь анги, байрлалаа орхин оргон зайлах, 9.2 хувь нь хүний амь нас хохироосон, 3.7 хувь нь галт зэвсэг, галт хэрэглэлтэй холбогдсон, 27.7 хувь нь бусдын бие махбодод гэмтэл учруулах, 5.5 хувь нь амиа хорлохыг завдсан, 3.7 хувь нь албан тушаалаа урвуулан ашигласан, 14.8 хувь нь авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн, 5.5 хувь нь хүчиндэх, 1.8 хувь нь дээрэм, 5.5 хувь нь хууль бус ан агнах, 11.1 хувь нь хулгай, 5.5 хувь нь цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг криминологийн үүднээс авч үзвэл, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, тэдгээрт нөлөөлөх олон хүчин зүйлээс хамаарах боловч Зэвсэгт хүчний дотоод хяналт, шалгалт сайжирч, нуугдмал гэмт хэргүүд илрэх, хууль эрх зүйн өөрчлөлттэй холбоотойгоор гэмт хэрэгт шинээр тооцох эсхүл гэмт хэрэг биш болох, гэмт хэрэг, сахилга дэг журмыг сайжруулах хүрээнд зохиогдож байгаа ажил, арга хэмжээний үр дүн, цаг үеийн хүчин зүйл /цар тахлын хөл хорионы дэглэмээс үүдэлтэй нийгмийн сэтгэл зүйн бухимдал, стресс гэх мэт/-тэй холбоотой юм.

Зэвсэгт хүчний хэмжээнд гарсан гэмт хэрэг, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбогдолтой осол, зөрчлийг Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар хариуцан, дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гарсан осол, зөрчлийг судлан бүртгэхэд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй

холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол 90 тохиолдол бүртгэгдсэнээс, 48 хүн хөнгөн, 30 хүн хүндэвтэр гэмтэл авч, 12 хүн нас барсан /усанд живсэн-8, РГД-5 гранат тэсэрснээс-2, авто осол-2/ байна. Үүнийг тухайн ослын шинж чанараар нь авч үзвэл дараах байдалтай байна.Үүнд:

№	Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол	Хөнгөн	Хүндэвтэр	Амь хохирсон
1	Санамсар болгоомжгүйгээс унах, бүдрэх, халтирах	19	3	
2	Эд зүйлд цохигдох, хавчуулагдах, дарагдах	10	5	
3	Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн хийсний улмаас	6	3	
4	Галт зэвсэг, галт хэрэглэл, хортой бодистой буруу харьцах	4	15	2
5	Авто осолд орсон		4	2
6	Усанд живсэн			8
7	Бусад	9		
Дүн		48	30	12
Нийт		90		

2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас 8 хүн, 2020 онд 20 хүн бэртэж гэмтэн, хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдсан бол 2019 онд гэмт хэргийн улмаас нас барсан цэргийн алба хаагч байхгүй харин хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 4 /усанд живсэн/, авто ослоор 3, золгүй байдлаар /амиа хорлосон, авто осол, өвчний улмаас/ 6 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар хүний амь эрсэдсэн гэмт хэрэг, осол, зөрчлийг авч үзэхэд, 2019 онд Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг 1, гэмт хэргийн шинжтэй үйлдэл 3 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 1 цэргийн алба хаагч нас барсан хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдолтой ослоор 2, авто ослоор 2, золгүй байдлаар /амиа хорлосон, өвчний улмаас/ 2 цэргийн алба хаагч, 1 энгийн ажилтан нас барсан нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад харъяаллын дагуу шалгуулжээ.

Дүрмийн бус харилцааны асуудлаас 1 хугацаат цэргийн алба хаагч нас барсан хэрэгт холбогдсон офицер хууль, хяналтын байгууллагаар шалгагдаж байна.

Түүнчлэн 2020 онд албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан удирдлагын байгууллагын 9 офицер, 1 ахлагч, нийт 10 хүн, нэгтгэл, анги, байгууллагад 928 офицер, 1690 ахлагч, 13 цэргийн гэрээт алба хаагч, 30 хугацаат цэргийн алба хаагч, 342 ажилчин албан хаагч, нийт 3003 хүнд “Цэргийн сахилгын дүрэм”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан байна.

2021 оны эхний улирлын байдлаар хугацаат цэргийн алба хаагчдаас болон ар гэрээс мөнгө авч байгаа талаар иргэдээс 2 өргөдлийг хүлээн авч, дотоод хяналт шалгалтыг хийж, холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл оногдуулсан байх бөгөөд хугацаат цэргийн алба хаагчдаас болон ар гэрээс мөнгө авч байгаа талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авч, шалгах үйл ажиллагаа үргэлжилж байна.

Сүүлийн үед эрхээ хэтрүүлсэн, үүргээ биелүүлээгүй цэргийн алба хаагч, албан тушаалтанд хариуцлага оногдуулах асуудал цахим орчинд хөндөгдөх болсноос цэргийн албаны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд онцгойлон анхаарч ажиллах шаардлага үүсжээ.

2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 28.1 дугаар зүйл /Тушаал биелүүлэхгүй байх/-ийн тайлбарт “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын

иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно” гэж тодорхойлсон бөгөөд 2016 онд батлагдсан Дотоодын цэргийн тухай хуульд зааснаар хугацаат цэргийн алба хаагчдыг цэргийн алба хаахтай холбогдуулан Эрүүгийн хуулийн энэхүү тайлбарт нэмэлт оруулах нь зүй байна.

2020 оны 1 сараас 2021 оны 6 сар хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийтгэх тогтоол гаргасан 11 тохиолдол бүртгэгджээ.¹⁴ Үүнд:

Зүйл	Гэмт хэргийн нэр	тоо
ЭХ-ийн 28.3	Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх	3
ЭХ-ийн 28.5	Цэргийн албанаас оргон зайлах	4
ЭХ-ийн 28.7	Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших	1
ЭХ-ийн 28.10	Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих	2
ЭХ-ийн 28.15	Хилийн алба хаах журам зөрчих	1
Нийт		11

БХЯ-наас сүүлийн 10 жилийн статистик мэдээлэлд үндэслэн, Зэвсэгт хүчний хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлүүдэд судлан цэргийн албанд хамааралтай дараах үндсэн шалтгаан, нөхцөлөөс үүдэлтэй гэж дүгнэжээ. Үүнд:

1.Нэгтгэл, анги, салбарт “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бусад удирдлагын баримт бичгүүдийг судлах, сурталчлах, хэрэгжүүлэх ажил хангалтгүй;

2. Зарим албан тушаалтны ажлын хариуцлага, санаачилга сул, цаг үеэ мэдэрч хандлага, сэтгэлгээгээ өөрчлөхгүй урсгалаар ажиллах, цэргийн алба хаагчдын хууль тогтоомж, дүрмийн мэдлэг дутмаг;

3. Залуу офицер, ахлагч нарыг хүнтэй ажиллах арга барилд сурган дадлагажуулах ажил бүрэн хэрэгждэггүй, тэдний ар гэр амьдрал ахуйг нарийвчлан судлах, тэдэнд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил дутмаг;

4. Цэргийн хангалт үйлчилгээг заавар, журмын дагуу зохион байгуулах асуудал дутагдалтай /санхүүгийн боломжоос шалтгаалдаг/;

5. Цэргийн албанд сахилга дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй цэргийн цагдаагийн салбар нэгжүүдийн үйл ажиллагааны эрх орчин бүрдээгүй, үйл ажиллагаа нь тогтмолжоогүй зэрэг болно. гэж дүгнэжээ.

2.2.2. ЦАХ-тай холбоотой эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штабаас гэмт хэрэг, бусад төрлийн зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээ хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгааг гардвал :

- Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цэргийн албаны болон цэргийн алба хаагчийн, ялангуяа хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

- Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх;

¹⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан. Эх сурвалж: https://shuukh.mn/cases/2/1?item_id=50.

Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Иргэний зөвлөл”-ийг байгуулж, “Иргэний зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталгаажуулж үйл ажиллагааг нь эхлүүлснээр Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын тогтолцоо бүрдэж, ард, олон нийтийн хяналт сайжирч, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нийгэмд илүү нээлттэй болно гэж дүгнэжээ.

- Цэргийн цагдаагийн үйл ажиллагааг жигдрүүлэн шуурхай удирдлага, зохицуулалтын тогтолцоог бий болгон бүх шатанд хүний эрхийн зөрчил, хүнлэг бус харьцааг гаргуулахгүй байхад шат шатны удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэн үйл ажиллагааг чиглүүлэх хүрээнд “Цэргийн цагдаа-2030” хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан баталж, цэргийн цагдаагийн бүлгүүдийг түшиглэн цэргийн хүрээ, хотхон бүрт цэргийн цагдаагийн 16 салбар, нэгжийг байгуулах шийдвэрийг 2021 оны 3 дугаар сард гаргаж “Цэргийн нийтлэг дүрмүүд”-д өөрчлөлт оруулах санал болон “Цэргийн цагдаагийн ажиллагааны журам”-ыг шинээр боловсруулан ажиллаж байна.

- Цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх судалгаа, бодит үнэлгээнд тулгуурлан хэрэгжүүлснээр цэргийн сургалтын хөтөлбөр, сургалтын тогтолцоо, арга хэлбэр, технологийг өөрчлөн цэргийн сургалт, цэргийн алба, цэргийн хүмүүжлийн асуудлын харилцан хамаарлыг зүй зохистойгоор нягт уялдуулах, тэр дундаа залуу офицер, ахлагч нарын зан байдал, төлөвшил, харилцааны ёс суртахуунд онцгой анхаарч тавих;

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сэтгэл зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилоод байна. Үүнтэй зэрэгцүүлэн сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах, төрийн албан хаагчийн ёс зүйг өндөржүүлэхийн тулд Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар, ёс зүйн түвшинг тогтоох үзлэг явуулахаар холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна.

Зэвсэгт хүчний 39 нэгтгэл, ангийн офицер 756, ахлагч 1760, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч 2626, нийт 5142 цэргийн алба хаагчдаас 17 асуултаар сорил авч залуучуудын үзэл бодол, итгэл үнэмшил илэрхийлэгдсэн санал, хүсэлтийг нарийвчлан судалж даруй хэрэгжүүлэх арга хэмжээг ангилан, хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг үе шаттай төлөвлөн ажиллаж байна.

- Бие бүрэлдэхүүний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, бие биедээ хүндэтгэлтэй хандах хандлагад онцгой анхаарч захиран тушаах уламжлалт арга барилаас илүүтэйгээр хүнлэг ёсыг бий болгон бүх шатны захирагч, дарга нарын манлайлал, үлгэр жишээч байдал, цэргийн дүрэмд заагдсан эелдэг зан, харилцаанд анхаарч, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх;

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн н/40 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабын бүтцэд “Цэргийн албаны хэлтэс”-ийг шинээр байгуулж, цэргийн албанд ёс зүй, сахилга дэг журмыг сахиулах, бэхжүүлэх, цэргийн албаны гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, бие бүрэлдэхүүний хууль ёсны эрх ашгийг хамгаалах цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын чадавхид ахиц гаргахаар зорилт тавин ажиллаж байна.

- Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын дотоод хяналт шалгалт, шалган зааварлах үйл ажиллагааг үр дүнтэй, дэвшилтэт арга механизмыг бүрдүүлэх замаар Зэвсэгт хүчний хэмжээнд гэмт хэрэг, сахилгын зөрчлийг бууруулах, таслан зогсоох, цэргийн нэгтгэл, ангийн камерын хяналтын системийг бүрдүүлэх;

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд БХЯ болон ЗХЖШ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилгахариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл” Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 23 дугаар зарлигаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-

ийн зөвлөмж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд”, Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/335, А/336, ЗХЖШ-ын даргын 2017 оны А/535 дугаар тушаал, даалгавар, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, зэвсэг, техник, галт хэрэглэл, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, осол, сахилгын зөрчилд дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг, чиглэлийг ЗХЖШ-ын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад тухай бүрд нь хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

- Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагад ажиллах нөхцөл, хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах, алба хаах орчныг орчин үеийн жишигт ойртуулан сайжруулах, материал, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчлэх;

“Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар 24 цагийн турш ажиллуулж батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой иргэдийн санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломж бүрдүүлж цэргийн алба хаагчдын дүрмийн бус харьцааг илрүүлэх, цэргийн алба, сахилга дэг журмын талаар ард иргэд болон цэргийн алба хаагчдаас гомдол, мэдээлэл авах бөгөөд мэдээлэл гаргагчийн нууцлалыг хадгалах юм.

Түүнчлэн Зэвсэгт хүчний ангиудад шаардлагатай хяналтын камер болон дагалдах хэрэгслийн судалгаа, тооцоог гаргаж, эхний ээлжинд хугацаат цэргийн алба хаагчидтай Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг камержуулах ажлыг 2021 оны II улиралд багтаахаар ажиллаж байна.

2.3. ЦАХЭЗБТ хуультай холбогдуулан гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт

2.3.1. ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг “Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу дараах журмыг батлагджээ. Үүнд:

1. *Засгийн газрын 2017 оны 09 дүгээр 27-ны өдрийн 286 дугаар тогтоолын 2-8 дугаар хавсралтаар батлагдсан “Цэргийн алба хаагчдын хувцас, хэрэглэл, хүнсний хангамжийн норм батлах тухай”¹⁵. Үүнд:*

- Тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 2 дугаар хавсралт,
- Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогчдын ажлын хувцас, ахуйн хэрэглэлийн нормыг 3 дугаар хавсралт,
- Цэргийн дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа бэлтгэл үүрэгтний хувцас, хэрэглэлийн нормыг 4 дүгээр хавсралт,
- Цэргийн анги, салбар, байгууллагын үйлчилгээний албан тушаалд ажилладаг алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 5 дугаар хавсралт,
- Цэргийн алба хаагчийн эд хогшлын эдэлгээний нормыг 6 дугаар хавсралт,
- Цэргийн алба хаагчийн хүнсний хангамжийн хоногийн нормыг 7 дугаар хавсралт,
- Хүнсний тоног төхөөрөмж, сав хэрэглэл, цэвэрлэгээний материалын нормыг 8 дугаар хавсралт

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/12930?lawid=12930>

2. Засгийн газрын 2019 оны 05 дугаар 29-ний өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийн норм”¹⁶

ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг “Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан боловч Засгийн газрын 2019 оны 05 дугаар 29-ний өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар гагцхүү Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийн нормыг тогтоосон байна.

Энэ нь онцгой байдлын байгууллага, хил, дотоодын цэргийн алба хаагчдад үл үйлчилэх төдийгүй нэгэнт цэргийн албаны харъяалалд багтаж байгаа байгууллагууд нь тус бүр энэхүү журмыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулснаар нэгдсэн стандарт тогтохгүй цаашид энэхүү журамд нэмэлт оруулах хууль зүйн үр дагаврыг бий болгоно.

2.3.2. ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу дараах журмууд батлагджээ. Үүнд:

1. Төрийн албаны тухай хуулийн 57.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хавсралтаар Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтаар баталжээ.

Харин ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газар зэвсэгт хүчин, гамшгаас хамгаалах, хил, дотоодын цэргийн алба хаагчдын цалингийн хэмжээг цэргийн алба “ЦА” эсхүл төрийн цэрэг “ТЦ” статусаар төрийн тусгай, хууль сахиулах байгууллагын алба хаагчдаас онцлогтойгоор тусдаа цалингийн сүлжээтэй болгон цаашид тэдгээрийн цалин, хөлс нэмэгдлийг үе шаттайгаар нэмэгдүүлэн цэргийн алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна гэж дүгнэлээ.

Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 9 дүгээр сарын хэвлэл, мэдээллийн байгууллагад өгсөн мэдээлэлд Монгол Улсад 25800 төрийн захиргаа, улс төрийн алба хаагч, 37500 төрийн тусгай алба хаагч, 50200 багш, 25400 эмч, сувилагч, асрагч, 1100 шүүгч, прокурор, 1700 шинжлэх ухааны ажилтан, 4500 соёл, урлагын ажилтан, 51600 бүх аштын төрийн байгууллагын үйлчилгээний албан хаагч 9700 иргэдийн хурлын төлөөлөгч, 78200 ТӨК, ТӨҮГ, ОНӨҮГ-ын ажилчид буюу нийт 285900 тэднээс 198000 төрийн алба хаагч байгаа талаар дурдсан.

Энэ нь төрийн тусгай алба хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтооход 37500 бол харин төрийн цэргийн цэрэг, тэдгээрийн эрх ашгийг хамгаалан цалин хөлсийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсны дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаар цэргийн алба хаагчийн цалингийн сүлжээг нууцын зэрэглэлд хамруулан үе шаттайгаар нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтын үндэс нь ЦАХЭЗБТ хуульд баталгаажуулагдсан гэж дүгнэгдэхээр байна.

2. Засгийн газрын 2000 оны 01 дүгээр 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай”¹⁷

¹⁶ <https://www.legalinfo.mn/law/details/14465?lawid=14465>

¹⁷ <https://www.legalinfo.mn/law/details/2859?lawid=2859>

3. Засгийн газрын 2004 оны 05 дугаар 26-ны өдрийн 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”¹⁸

2002 оны Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Засгийн газрын 2004 оны 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг баталсан байх бөгөөд энэхүү хууль 2016 онд шинэчлэн найруулагдсан төдийгүй захиргааны хэм хэмжээ тогтоох хууль зүйн үндсийг ЦАХЭЗБТ хуульд заасан тул Засгийн газрын тогтоолын үндэслэлийг шинэтгэх хууль зүйн үр дагаврыг бий болгожээ.

ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан бөгөөд Засгийн газрын 2000 оны 02 дугаар тогтоол, 2004 оны 123 дугаар тогтоолын хавсралтуудаар гагцхүү зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдад хамаарахаар зохицуулсан тул 2016 оны ЦАХЭЗБТ тухай хуульд заасны дагуу энэхүү журмуудын зохицуулалтын хүрээг Цэргийн албаны хуульд заасан агуулгатай нийцүүлэх нь зүйтэй байна.

4. Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ”¹⁹ -г шинэчлэн тогтоосон байна.

Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ”-г Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасныг үндэслэсэн байх ба энэхүү хууль 2016 онд Цэргийн албаны тухай хууль, ЦАХЭЗБТ хууль болон шинэчлэгдэн найруулагдсан тул Засгийн газрын тогтоолын үндэслэлийг шинэчлэн залруулах нь зүй.

5. Төрийн албыг өндөр мэдлэгтэй хүний нөөцөөр бэхжүүлэх, төрийн албан хаагчид эрдэм боловсролоо дээшлүүлж байх сонирхлыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам” батлагдан цэргийн алба хаагчдад үйлчилж байна.

2.3.3. ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан боловч батлагдсан талаар эх сурвалжийн мэдээлэл олдоогүй буюу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/advanced-search> болон БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штабын сайтуудад байршаагүй байх тул дүн шинжилгээ хийх боломжгүй байлаа.²⁰

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

2016 оны ЦАХЭЗБТ хуулийн “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхдээ аргачлалын дагуу хууль батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг шалган хууль бүхэлдээ зорилго, зорилтдоо нийцсэн эсэхийг үнэлэх юм.

¹⁸ <https://www.legalinfo.mn/law/details/2859?lawid=2859>

¹⁹ <https://www.legalinfo.mn/law/details/5537>

²⁰ 2016 оны ЦАХЭЗБТ хууль хэрэгжснээс хойш өнөөгийн байдлаар энэхүү журмыг Засгийн газар батлаагүй байж болно. Судлаач.

Хууль батлагдах үеийн үзэл санааг 2016 оны Батлан хамгаалахын тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай болон 2018 оны Төрийн албаны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын үндсэн зорилгод суурилан ЦАХЭЗБТ хуулийн нэршил, хууль зүйн техникийн хувьд харьцуулан 1 дүгээр зүйлийг үнэлгээний зүйлээр сонгон авч үзлээ.

3.1.1 Үнэлгээний зүйл 1

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтооход оршино.

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно” гэж тодорхойлжээ.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ЦАХЭЗБТ хуулийн 7, 8 дугаар зүйлийн “бэлтгэлээр халагдах” нэр томъёо, 4 дүгээр зүйлийн 4.3.9 дэх заалтын “энхийг дэмжих ажиллагаанд оролцох”, ЦАХЭЗБТ хуульд нь 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр орсон өөрчлөлтүүдийг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв.

3.2.1. Үнэлгээний зүйл 1

ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтуудыг Төрийн албан тухай хууль, Цэргийн албаны хуулийн үзэл баримтлал, уялдаа холбоо, энэ зүйлд заасан “халагдах” гэсэн нэр томъёоны хууль зүйн техникийг үнэлэв.

7 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн давуу эрх

7.1.Цэргийн алба хаагч дараахь давуу эрхийг эдэлнэ:

7.1.14.офицер, ахлагч шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүнийг гэр бүлийн гишүүд, ачаа тээшний хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн хэрэгслийг анги, байгууллагаас гаргах буюу зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож олгох;

8 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт

8.1.Цэргийн алба хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.7.хуулийн дагуу нууцын зэрэгт хамаарах баримт бичиг, зэвсэг, техник хэрэгсэлтэй ажиллаж байсан цэргийн алба хаагч цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа гурван жилийн дотор гадаад улсад байнга оршин суухаар явах;

Төрийн албаны тухай болон Цэргийн албаны хуульд чөлөөлөх, халах гэсэн нэр томъёог хууль зүйн техникийн хувьд хэрхэн хэрэглэснийг харьцуулалтаар дүгнэвэл:

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт	Цэргийн албаны тухай хууль 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг
Чөлөөлөх	
1.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон; 2.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн; 3.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн; 4.өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;	1. анги, байгууллага татан буугдсан, орон тооны өөрчлөлтөөр албан тушаал нь хасагдсан; 2. өөр ажилд томилогдсон; 3. цэргийн жинхэнэ албанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй тухай цэргийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлт гарсан; 4. тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн; 5. алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

5.хуульд заасан бусад үндэслэл.	6. өөрийн хүсэлтээр.
Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт	Цэргийн албаны тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг
Халах	
Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас хална: 1.хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /3 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн; 2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 3.Монгол Улсын харьяатаас гарсан; 4.энэ хуульд заасан бусад үндэслэл.	1. цэргийн нийтлэг дүрэм, цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн; 2. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 3. ЦАТ хуульд заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшинд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон.

Харин Цэргийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд цэргийн албанаас хугацаат цэргийн алба хаагчийг бэлтгэлээр халах ойлголт тусгагдсан байна.

Иймд 2016 оны ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтын “... бэлтгэлээр халагдах үед ...” гэснийг “... Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн бол”, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын “... бэлтгэлээр халагдсаны дараа.... ” гэснийг “ халагдсан, чөлөөлөгдсний дараа ...” гэж тус тус хууль зүйн техникийн хувьд засах шаардлагатай байна.

Үнэлгээний зүйл 2

ЦАХЭЗБТ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.9-т заасан цэргийн алба хаагчид энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн зохицуулалтыг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилттэй холбогдуулан дүгнэв.

ЦАХЭЗБТ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

4.3. Энэ зүйлийн 4.2-т зааснаас гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:

“4.3.9. энхийг дэмжих ажиллагаанд оролцох;”

2002 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Цэрэг, цагдаагийн албан хаагчийг нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш НҮБ-ын энхийг сахиулах үйлсэд оролцуулсан алба хаагчдынхаа тоогоор дэлхийд 22 дугаарт жагсаж байна.

2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль /цаашид ЭДАОТ хууль гэх/-ийн 9 дүгээр зүйлд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал тодорхойлсны зэрэгцээ 10 дугаар зүйлийн 10.3.”Бие бүрэлдэхүүний урьд эрхэлж байсан албан тушаалыг хэвээр хадгалж, өөрөө зөвшөөрсөн тохиолдолд цалин, нэмэгдлийг итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.” гэж заасан байна.

2010 оны ЭДАОТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт “Энхийг дэмжих ажиллагаанд зэвсэгт хүчний цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.” гэж заасан байна.

Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 270 дугаар тогтоолын 1-т “Энхийг дэмжих ажиллагаанд зэвсэгт хүчний цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардлыг НҮБ-ын ажиллагаанд цэрэг оролцуулсны

нөхөн төлбөр болон тусгай мэргэжилтний нэмэгдлийн 70 хувиар тогтоосугай.” 2-т “НҮБ-ын ажиллагаанд цэрэг оролцуулсны нөхөн төлбөр болон тусгай мэргэжилтний нэмэгдлийн үлдэх 30 хувийг Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлж байхыг ... даалгасугай. “ гэжээ.

Цэргийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагаанд оролцож томилолтын зардлыг 70 хувиар авч улмаар Монгол Улсад авч байсан албан тушаалын цалин, нэмэгдлийг олгох эрх зүйн зохицуулалт нь цэргийн алба хаагч, тэдгээрийн гэр бүлийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах томоохон хөшүүрэг болдог байна.

Түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд оролцохын тулд холбогдох хууль эрх зүй, бие бялдарын болон хэлний шалгуурыг хангах шаардлагатай бөгөөд БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сургалтын төвд цэргийн алба хаагчдыг суралцуулж зохих шалгуурыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлдэг нь байна.

Монгол Улс дэлхийн өнцөг булан бүр дэх НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд нийт 19.000 гаруй, үүний дотор 732 эмэгтэй цэргийн алба хаагчаа илгээгээд байгаа билээ.

2021 оны 05 дугаар 29-ны байдлаар Монгол Улсын 1100 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь НҮБ-ын бүрэн эрхийн хүрээнд БНӨСУ дахь мөргөлдөөний бүсэд аюулгүй, тайван орчныг бүрдүүлэх, энгийн иргэдийг хүчирхийллээс хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч Тапан Мишра нь Монгол Улс тогтвортой энх тайван, аюулгүй байдал, хөгжлийн замыг бүс нутагтаа, дэлхийн хэмжээнд үлгэр жишээ болгон харуулж байна гэж дүгнэжээ.²¹

НҮБ-ын “UNMISS” ажиллагааны Цэргийн хүчний командлагч, дэслэгч генерал Шайлеш Тинайкарын ярилцлагаас²²....

... миний удирдлагад үүрэг гүйцэтгэж байгаа Монголын цэргийн багууд НҮБ-ын мандатад заагдсан үүргээ ямагт мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж ирсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар өндөр болохыг зөвхөн энэ ажиллагаа бус НҮБ-ын бусад ажиллагаанд дахь оролцооноос харж болох юм.

... Монголын цэргийн багийн алба хаагчид маш сайн сургагдсан, бусдыг манлайлах, энхийг цогцлооход тэргүүн эгнээнд байж үлгэр жишээ нь болсоор байна гэж дүгнэжээ.

Үнэлгээний зүйл 3

ЦАХЭЗБТ хуульд 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр өөрчлөлт оруулахдаа хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.17, 7.1.21 дэх заалтыг хүчингүй болгож, мөн зүйлийн 7.1.1, 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан хуулийн зохицуулалтад доорхи өөрчлөлтийг оруулсныг дүгнэв.²³ Үүнд:

- “7.1.7.цэргийн анги, байгууллага, офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг орон сууцаар хангаагүй бол орон сууц, гэр, байшин хөлслөх тухайн орон нутгийн түрээсийн төлбөрийг 12 хавтгай дөрвөлжин метрээр тооцож цэргийн анги, байгууллага олгох;”

²¹ БХЯ-ны цахим сайтын мэдээллээс....

²² БХЯ-ны цахим сайтын мэдээллээс

²³ЦАХЭЗБТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангаас

- “7.1.17.улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;

- “7.1.21.цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох” гэсэн 3 заалтыг хүчингүй болгосон.

Мөн уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч жил бүр ажлын 18 өдрийн амралт биеэр эдлэх” гэж заасныг “15 өдөр” гэж, 7.1.10 дахь заалтын “гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлсийг ... төр хариуцах” гэж заасныг “сургалтын тэтгэлэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийг газрын гишүүн батална.” гэснийг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж тус тус өөрчилсөн байна.

Эдгээр нэмэлт, өөрчлөлтийг дүгнэн үзвэл:

Улс орны эдийн засгийн байдал, Олон Улсын Валютын сангаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөртэй холбогдуулан ЦАХЭЗТ хуульд өөрчлөлт оруулснаар алба хаагчдыг орон байраар хангах, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломж хязгаарлагдаж, алслагдсанд тооцох ангид алба хааж мөнгөн урамшуулал авах алба хаагчдын итгэл, зүтгэлийг үл ойшоосон алхам болсон байна.

Орон нутагт ажиллаж буй цэргийн алба хаагч Д-тэй хийсэн ярилцлагаас: ...

Би тушаалаар томилогдон ирээд 4 жил ажиллаж байна...ангиас орон сууцаар хангаагүй бөгөөд энэ хугацаанд түрээсээр айлын байшин хөлсөлж суудаг... дахиад шилжиж магадгүй учраас байшин барихаар дараа нь зарагдахгүй ... илүү зардал болох байх гэж боддог. Уг нь ЦАХЭЗБТ хуульд түрээстэй холбоотой зохицуулалт байсан ч УИХ хүчингүй болгочихсон... Манай хүн цэргийн хүний эхнэр тулдаа чимээгүй байх юм даа...

Улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад хөдөө орон нутаг дахь анги, салбарт алба хааж байгаа офицер, ахлагч нараас нийт 1600 орчим албан хаагч буюу өрх түрээсийн байр, хашаа байшинд амьдарч байна.²⁴

Цэргийн алба хаагч нь удирдах дээд байгууллагаас өгсөн тушаалын дагуу тогтоосон газарт үүрэг гүйцэтгэх ажлын албаны онцлогтой билээ.

Хүний нөөцийн асуудал эрхэлсэн цэргийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас: ... Урьд нь цэргийн алба хаагчид гадаадын цэргийн сургуульд магистр, докторантурт суралцах их сонирхолтой байсан нь суралцах хугацаандаа цалин, хөлсөө авдаг байсантай холбоотой... Харин ЦАХЭЗБТ хуульд байсан энэхүү уламжлалт цэргийн алба хаагчийн баталгаа үгүйсгэгдснээр гадаадад суралцан мэдлэг, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэх алба хаагчдын тоо, хандлага илтэд буураад байна. ... Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын хэмжээнд л яригдах чухал сэдэв шүү дээ. ... Бид олон улсын цэргийн шинжлэх ухаантай хөл нийлүүлэн алхах, туршлага харилцан судлах учиртай л баймаар

²⁴ ЦАХЭЗБТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлангаас

ЦАХЭЗБТ хуулиар алба хаагчийн гадаадын цэргийн сургуульд суралцах хугацаандаа албан тушаалын цалин авч, уг цалинг үндэслэн ажилласан жилийг тасралтгүй тооцох зохицуулалт үйлчилж байсан байна.

Гэвч албан тушаалын цалин, хөлсийг тэтгэлэг болгон өөрчилснөөр гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагч цэргийн алба хаагчийн өрхийн орлого буурах, цаашлаад тэтгэвэр тогтоолгоход нөлөөлөх зэрэг сөрөг хүчин зүйл нэгэнт бий болсон байна.

Цэргийн алба хаагчтай хийсэн ярилцлагаас: ... Цэргийн алба хаагч нь удирдах дээд байгууллагаас өгсөн тушаалын дагуу алслагдмал хөдөө орон нутагт албаа хаадаг. Гэтэл ЦАХЭЗБТ хуульд бидэнд урамшуулал олгох нь баярлаж байтал УИХ-аас буцаагаад хүчингүй болгочихсон.Хил хамгаалах болон цагдаагийн байгууллага хуульдаа дээрхтэй агуулга зохицуулалтыг тусган хэрэгжүүлснээс төв суурин газар луу тэмүүлсэн шилжилт хөдөлгөөнөө зогсоож чадсан... Цаашлаад бидний авч байгаа цалин, хөлс нь улс оронд болж байгаа мөнгөний инфляцитай харьцуулбал улам бүр үнэгүйдээд л байна дээ. ... Энэ урамшуулал нь байвал төрөөс мартсан цэргийн алба хаагчид, тэдгээрийн гэр бүлд их л дэмжлэг болно доо ...

Цэргийн анги, байгууллагаас авсан судалгаагаар 2019 онд алслагдсан цэргийн анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа 60 орчим цэргийн алба хаагч байна.²⁵

Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг “Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.” гэж заасан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэг “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан байна.

Энэхүү зохицуулалтууд нь цагдаа, хилийн цэргийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нийгэм, эдийн засгийн баталгааг хангаж багаас сум, сумаас аймаг, аймгаас нийслэл лүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг зохицуулж түүнчлэн байгууллагуудын удирдлагад ирэх гуйлт, дарамт, шахалт, өргөдөл, хүсэлтүүдийг нэг мөр шийдвэрлэж чадсан байдаг байна.

Харин ЦАХЭЗБТ хуульд хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21 дэх заалт “цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицер урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.” гэснийг хүчингүй болгосон.

Энэ нь цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицер нь тэтгэвэр тогтоолгохдоо дээд офицерын албан тушаал, цолны нэмэгдлийг тооцон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоолгосон бөгөөд дахин тэтгэвэрт байх хугацаандаа урьд эдэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг сар бүр олгох нь Монгол Улсын Үндсэн хуулийн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, .. оор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэсэн зарчимтай нийцэхгүй байсантай холбоотой байна.

²⁵ ЦАХЭЗБТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлангаас

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчаас санаачилсан 2016 оны Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд цэргийн жинхэнэ алба хаагчийн эрх зүйн байдлыг иргэний цэргийн үүргээс тусад зааглаж цэргийн алба хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг дээшлүүлэх, үүрэг хариуцлага, хязгаарлалтыг шинээр тодорхойлжээ.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг Батлан хамгаалахын тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудаар зохицуулахаас гадна хуульд заасан цэргийн албаны үндсэн чиг үүргийн онцлогоос улбаалан Монгол Улсын хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Дотоодын цэргийн тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдал нь Төрийн албаны тухай хууль, ЦАХЭЗБТ хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, НАНБХАСЗАСЗУСТ хуульд заасан эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдахгүй билээ. Үүнд:

- Батлан хамгаалахын тухай хууль
- Зэвсэгт хүчний тухай хууль
- Цэргийн албаны тухай хууль
- Дайчилгааны тухай хууль
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль
- Цэргийн алба, алба хаагчидтай холбоотой бусад хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд

Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйл /Зэвсэгт хүчний чиг үүрэг/-ийн 6.2.11 дэх заалт “бүтээн байгуулалтын ажилд оролцох;” чиг үүргийг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан төдийгүй энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.” гэж улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад Монгол Улсын Зэвсэгт хүчин оролцох шинэ үүргийг тодорхойлсон байна.

Энэхүү үүргийн хувьд Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний ордын төмөр бетон гүүр, Дорнод аймгийн Халх гол сумын шинэ бүтээн байгуулалт, газрын тосны үйлдвэрийн хүнд даацын авто зам, Зүүнбаян Тавантолгой чиглэлийн төмөр замын доод суурь, дэд бүтцийн ажил, тус төмөр замыг дагасан дэд бүтэц буюу нэг өртөө, зургаан зөрлөгийн барилгын ажлыг Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчид богино хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэжээ.

Улмаар газрын тосны үйлдвэрийн дэд бүтэц буюу орон сууцны хорооллуудыг барих ажлыг Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн гүйцэтгэж байгаа ба ялангуяа хугацаат цэргийн алба хаагчид шинэ мэргэжилтэй болох, мэргэшил эзэмших, дадлага туршлагатай болж албаа дуусгахдаа цалин, хөлсний хуримтлалыг бүрдүүлж эдийн засгийн боломжит нөхцөлтэй болж байгаа нь тэдгээрийн эрх зүй байдалд эерэгээр нөлөөлж байна.

Түүнчлэн Монгол Улс дэлхийн өнцөг булан бүр дэх НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд нийт 19.000 гаруй, үүний дотор 732 эмэгтэй цэргийн алба хаагчаа илгээсэн байх бөгөөд 2021 оны 05 дугаар 29-ны байдлаар Монгол Улсын 1100 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэж байгаа, тэдгээрийн дийлэнх нь НҮБ-ын бүрэн эрхийн хүрээнд БНӨСҮ

дахь мөргөлдөөний бүсэд аюулгүй, тайван орчныг бүрдүүлэх, энгийн иргэдийг хүчирхийллээс хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Цэргийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагаанд оролцож томилолтын зардлыг 70 хувиар авч улмаар Монгол Улсад авч байсан албан тушаалын цалин, нэмэгдлийг олгох эрх зүйн зохицуулалт нь цэргийн алба хаагч, тэдгээрийн гэр бүлийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах томоохон хөшүүрэг болдог байна.

2016 оны Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжлтийн үр дагаврыг дараах байдлаар дүгнэж байна Үүнд:

4.1. ЦАХЭЗБТ хуулийг бүхэлд нь зорилгодоо нийцсэн эсэхийг авч үзвэл, УИХ-аас батлагдсан “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын нийгмийн шаардлагын хүрээнд Батлан хамгаалахын тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай хуулиудын үзэл баримтлалд тулгуурлан улам бүр боловсронгуй болсон байна.

Цаашид хууль сахиулах салбарын төрийн тусгай алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд Цэргийн албаны хуульд тусгагдсан цэргийн алба хаагчийн зарим эрх зүйн байдлын эрх зүйн зохицуулалтыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нэгтгэн шинэтгэх шаардлага гарахаар байна.

Тухайлбал, Цэргийн албаны тухай хуульд заасан “Цэргийн жинхэнэ алба хаах журам” бүлгийн 22 дугаар зүйл /Цэргийн алба хаагчийг албан тушаалаас чөлөөлөх/, 23 дугаар зүйл /Албан тушаал бууруулан томилох/, 24 дүгээр зүйл /Цэргийн жинхэнэ албанаас халах/ эрх зүйн зохицуулалтууд нь ЦАХЭЗБТ тухай хуулийн цэргийн алба хаагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, үйл ажиллагааны хязгаарлалттай холбоотой учраас энэхүү хуулийн бүтцэд байх нь оновчтой байна.

4.2. Аргачлалын дагуу “практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр гарсан дүгнэлтийг нэгтгэн үзвэл, Улсын Их хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 5.6-д “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасныг удирдлага болгон 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн ЦАХЭЗБ тухай хуульд орсон өөрчлөлтөөр хүчингүй болгосон заалтуудыг эргүүлэн тусгах, өөрчлөлт оруулсан заалтыг хуучин хүчин төгөлдөр үйлчилж байсан хэвээр хуульчилснаар цэргийн алба хаагчдын эрх зүйн баталгааг хуучин мөрдөж байсан хуулийн төвшинд хүргэх боломжтой байна.

Тухайлбал, ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.17 дахь “улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;” заалт хүчингүй болсон.

Харин Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасан эрх зүйн зохицуулалтууд нь цагдаа, хилийн цэргийн албан хаагчдыг алслагдсанд тооцогдох орон нутагт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нийгэм, эдийн засгийн баталгааг хангаж багаас сум, сумаас аймаг, аймгаас нийслэл лүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг зохицуулж түүнчлэн байгууллагуудын удирдлагад ирэх гуйлт, дарамт, шахалт, өргөдөл, хүсэлтүүдийг нэг мөр шийдвэрлэж чадсан байдаг байна.

4.3. ЦАХЭЗБТ хуульд заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргах эрх зүйн зохицуулалтыг батлан гаргасан огноо, хуулийн үндэслэл, зохицуулалтын аргаар судлан үзэхэд дараах нөхцөл байдал дүгнэгдэж байна. Үүнд:

4.3.1. Төрийн албаны тухай хуулийн 57.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хавсралтаар Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтаар баталжээ.

Харин ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газар зэвсэгт хүчин, гамшгаас хамгаалах, хил, дотоодын цэргийн алба хаагчдын цалингийн сүлжээг цэргийн алба “ЦА” эсхүл төрийн цэрэг “ТЦ” статусаар төрийн тусгай, хууль сахиулах байгууллагын алба хаагчдаас онцлогтойгоор тусдаа цалингийн сүлжээтэй болгон цаашид тэдгээрийн цалин, хөлс нэмэгдлийг үе шаттайгаар нэмэгдүүлэн цэргийн алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг хангах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна гэж дүгнэлээ.

Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 9 дүгээр сарын хэвлэл, мэдээллийн байгууллагад өгсөн мэдээлэлд Монгол Улсад 25800 төрийн захиргаа, улс төрийн алба хаагч, 37500 төрийн тусгай алба хаагч, 50200 багш, 25400 эмч, сувилагч, асрагч, 1100 шүүгч, прокурор, 1700 шинжлэх ухааны ажилтан, 4500 соёл, урлагын ажилтан, 51600 бүх шатны төрийн байгууллагын үйлчилгээний албан хаагч 9700 иргэдийн хурлын төлөөлөгч, 78200 ТӨК, ТӨҮГ, ОНӨҮГ-ын ажилчид буюу нийт 285900 тэднээс 198000 төрийн алба хаагч байгаа талаар дурдсан.

Энэ нь төрийн тусгай алба хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтооход 37500 бол харин төрийн цэргийн цэрэг, тэдгээрийн эрх ашгийг хамгаалан цалин хөлсийг нэмэгдүүлэхэд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсны дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаар цэргийн алба хаагчийн цалингийн сүлжээг нууцын зэрэглэлд хамруулан үе шаттайгаар нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтын үндэс нь ЦАХЭЗБТ хуульд баталгаажуулагдсан гэж дүгнэгдэхээр байна.

4.3.2. ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг “Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан боловч Засгийн газрын 2019 оны 215 дугаар тогтоолын хавсралтаар гагцхүү Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийн нормыг тогтоосон байна.

Иймээс цэргийн албанд харьяалагдах онцгой байдал, хил, дотоодын цэргийн алба нь тус бүр энэхүү журмыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулснаар нэгдсэн стандарт тогтохгүй байх цаашид энэхүү журамд нэмэлт оруулах хууль зүйн үр дагаврыг бий болгохоор байна.

4.3.3. 2002 оны Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Засгийн газрын 2004 оны 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг баталсан байх бөгөөд энэхүү хууль 2016 онд шинэчлэн найруулагдсан төдийгүй захиргааны хэм хэмжээ тогтоох хууль зүйн үндсийг ЦАХЭЗБТ хуульд заасан тул Засгийн газрын тогтоолын үндэслэлийг шинэтгэх хууль зүйн үр дагаврыг бий болгожээ.

4.3.4. ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан бөгөөд Засгийн газрын 2000 оны 02 дугаар тогтоол, 2004 оны 123 дугаар тогтоолын хавсралтуудаар гагцхүү зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдад

хамаарахаар зохицуулсан тул 2016 оны ЦАХЭЗБТ тухай хуульд заасны дагуу энэхүү журмуудын зохицуулалтын хүрээг Цэргийн албаны хуульд заасан агуулгатай нийцүүлэх нь зүйтэй байна.

4.3.5. Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ”-г Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасныг үндэслэсэн байх ба энэхүү хууль 2016 онд Цэргийн албаны тухай хууль, ЦАХЭЗБТ хууль болон шинэчлэгдэн найруулагдсан тул Засгийн газрын тогтоолын үндэслэлийг залруулах нь зүйтэй байна.

4.3.6. ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэж заасан боловч батлагдсан талаар эх сурвалжийн мэдээлэл олдоогүй буюу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/advanced-search> болон БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штабын сайтуудад байршаагүй байх тул дүн шинжилгээ хийх боломжгүй байлаа.

ТАВ. САНАЛ

Батлан хамгаалахын сайдын дэргэд байгуулагдах “Иргэний зөвлөл”-ийн үйл ажиллагаагаар Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нийгэмд илүү нээлттэй болж иргэний хяналтын тогтолцоо бүрдэх ялангуяа Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан цэргийн алба хаагчдын эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгааны талаар холбогдох судалгааг хийн зохих өөрчлөлтийг хийнэ гэж дүгнэн дараах саналуудыг гаргаж байна.

1.1. Иймд 2016 оны ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтын “.... бэлтгэлээр халагдах үед ...” гэснийг “... Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн бол”, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын “... бэлтгэлээр халагдсаны дараа.... “ гэснийг “ халагдсан, чөлөөлөгдсний дараа ...” гэж тус тус хууль зүйн техникийн хувьд засах;

1.2. 2016 оны ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлд дараах заалтуудыг нэмэх. Үүнд:

- 7.1.7.цэргийн анги, байгууллага офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг орон сууцаар хангаагүй бол орон сууц, гэр, байшин хөлслөх тухайн орон нутгийн түрээсийн төлбөрийг 12 хавтгай дөрвөлжин метрээр тооцож цэргийн анги, байгууллага олгох;
- 7.1.17.улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;

1.3. ЦАХЭЗБТ хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.” гэснийг “Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг, батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж өөрчлөн найруулах;

1.4. ЦАХЭЗБТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын “сургалтын тэтгэлэг” гэснийг “цалин хөлс” гэж өөрчлөх;

1.5. Цэргийн алба хаагчдын цалингийн сүлжээг цэргийн алба “ЦА” эсхүл төрийн цэрэг “ТЦ” статусаар төрийн тусгай, хууль сахиулах байгууллагын алба хаагчдаас онцлогтойгоор тусдаа цалингийн сүлжээтэй болгох асуудлыг судлах

1.6. Засгийн газрын 2000 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай”, 2004 оны 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ” журмуудын тогтоолын захиргааны хэм хэмжээ тогтоох үндэслэлүүдийг ЦАХЭЗБТ хуульд зааснаар шинэтгэх, журмуудын үйлчлэлийг зэвсэгт хүчин болон бусад цэргийн алба хаагчид хамаарахаар зохицуулах

1.7. Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг боловсруулан Засгийн газраар батлуулах ажлыг зохион байгуулах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2016.09. 01, Төрийн мэдээлэл № 36. 2016
3. Цэргийн албаны тухай хууль. 2016.09. 01. Төрийн мэдээлэл № 36. 2016
4. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994.06.13 төрийн мэдээлэл №8
5. Төрийн албаны тухай хууль
6. Гамшгаас хамгаалах тухай хууль
7. Цагдаагийн албаны тухай хууль
8. Дотоодын цэргийн тухай хууль
9. Монгол Улсын хилийн тухай хууль
10. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль 2018 Төрийн мэдээлэл № 28

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” бодлогын баримт бичиг
2. Монгол Улсын Их хурлын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” бодлогын баримт бичиг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 17 дугаар зарлигаар батлагдсан Цэргийн нийтлэг дүрмүүд
 - Цэргийн дотоод албаны дрэм
 - Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм
 - Цэргийн жагсаалын дүрэм
 - Цэргийн сахилгын дүрэм
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдөр 181 дүгээр зарлигаар батлагдсан Цэргийн цол олгох журам

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. Засгийн газрын 2017 оны 09 дүгээр 27-ны өдрийн 286 дугаар тогтоолын 2-8 дугаар хавсралтаар батлагдсан “Цэргийн алба хаагчдын хувцас, хэрэглэл, хүнсний хангамжийн норм батлах тухай”. Үүнд:
 - Тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 2 дугаар хавсралт,
 - Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогчдын ажлын хувцас, ахуйн хэрэглэлийн нормыг 3 дугаар хавсралт,
 - Цэргийн дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа бэлтгэл үүрэгтний хувцас, хэрэглэлийн нормыг 4 дүгээр хавсралт,
 - Цэргийн анги, салбар, байгууллагын үйлчилгээний албан тушаалд ажилладаг алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 5 дугаар хавсралт,
 - Цэргийн алба хаагчийн эд хогшлын эдэлгээний нормыг 6 дугаар хавсралт,
 - Цэргийн алба хаагчийн хүнсний хангамжийн хоногийн нормыг 7 дугаар хавсралт,

- Хүнсний тоног төхөөрөмж, сав хэрэглэл, цэвэрлэгээний материалын нормыг 8 дугаар хавсралт

2. Засгийн газрын 2019 оны 05 дугаар 29-ний өдрийн 215 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийн норм”

3. Засгийн газрын 2000 оны 01 дүгээр 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай”

4. Засгийн газрын 2004 оны 05 дугаар 26-ны өдрийн 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”

5. Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ”

6. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”

7. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”

Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/advanced-search>
- <http://www.parliament.mn/files/125798>

Хавсралт № 1**ЦАХ-ИЙН АЖИЛЛАСАН ХУГАЦААГ ӨСГӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД**

№	Хуулийн нэр	огноо	Хугацааг өсгөн тооцох хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт
1	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль	2016 09.01	7.1.3.тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн отряд, застав болон тэдгээртэй адил нөхцөлд байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох;
2	Дотоодын цэргийн тухай хууль	2017 02.09	36.3.Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно.
3	Гамшгаас хамгаалах тухай хууль	2017 02.02	50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно

Хавсралт № 2**ЦАХ-ИЙН АЖИЛЛАХ НАСНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Хуулийн нэр	Ажиллах насны дээд хязгаар заасан зүйл хэсэг, заалтууд
1	Цэргийн албаны тухай хууль	10.5.Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана. 10.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай ахлагчийн цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. 11.4.Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаана. 11.5.Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана. 11.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай офицерын цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно. 11.7.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан цэргийн сургуулийн багш, цэргийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн офицерын алба хаах хугацааг дахин сунгаж болно.
3	Төрийн албаны тухай хууль	41 дүгээр зүйл.Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа 41.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.

I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт
- 2 дугаар зүйл. Цэргийн албаны тухай хууль тогтоомж
- 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
- 4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг
- 5 дугаар зүйл. Цэргийн тангараг

II БҮЛЭГ. ЦЭРГИЙН АЛБА, ТҮҮНИЙ АНГИЛАЛ, ТӨРӨЛ

- 6 дугаар зүйл. Цэргийн алба, түүний төрөл
- 7 дугаар зүйл. Хугацаат цэргийн алба
- 8 дугаар зүйл. Цэргийн гэрээт алба
- 9 дүгээр зүйл. Цэргийн сургуулийн сонсогч, сурагч
- 10 дугаар зүйл. Ахлагчийн алба
- 11 дүгээр зүйл. Офицерын алба

III БҮЛЭГ. ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАХ, ХАЛАХ, ЧӨЛӨӨЛӨХ, НӨХӨН ХААЛГАХ

- 12 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанд татах
- 13 дугаар зүйл. Цэрэг татлагын товчоо
- 14 дүгээр зүйл. Хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөх, нөхөн хаалгах
- 15 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанаас халах
- 16 дугаар зүйл. Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх

IV БҮЛЭГ. ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНД ЭЛСҮҮЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 17 дугаар зүйл. Цэргийн гэрээт албанд элсүүлэх
- 18 дугаар зүйл. Цэргийн гэрээт алба дуусгавар болох

V БҮЛЭГ. ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБА ХААХ ЖУРАМ

- 19 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах болзол
- 20 дугаар зүйл. Офицер, ахлагчийн албан тушаалыг түр хавсран гүйцэтгэх
- 21 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах
- 22 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийг албан тушаалаас чөлөөлөх
- 23 дугаар зүйл. Албан тушаал бууруулан томилох
- 24 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ албанаас халах

VI БҮЛЭГ. ЦЭРГИЙН ЦОЛ

- 25 дугаар зүйл. Цэргийн цол
- 26 дугаар зүйл. Цэргийн цол олгох албан тушаалтан
- 27 дугаар зүйл. Цэргийн цолыг хэрэглэх
- 28 дугаар зүйл. Цэргийн цолыг бууруулах, хураан авах, сэргээх

VII БҮЛЭГ. ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

- 29 дүгээр зүйл. Цэргийн дүйцүүлэх алба, түүний төрөл
- 30 дугаар зүйл. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
- 31 дүгээр зүйл. Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах

VIII БҮЛЭГ. ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ АЛБА ТҮҮНИЙ СУРГАЛТ

- 32 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл алба
- 33 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албаны сургалт

IX БҮЛЭГ. ЦЭРГИЙН БҮРТГЭЛ

- 34 дүгээр зүйл. Цэргийн бүртгэл

X БҮЛЭГ. ОФИЦЕР, АХЛАГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ, ТОО БҮРТГЭЛ, ХУВИЙН БАРИМТ БИЧИГ

- 35 дугаар зүйл. Хувийн хэрэг, тоо бүртгэл, хувийн баримт бичиг

XI БҮЛЭГ. АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 36 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУДЫН
ХОЛБОГДОХ ЗҮЙЛ ЗААЛТУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Төрийн албаны тухай хууль	ЦАХЭЗБТ хууль	Гамшгаас хамгаалах тухай хууль	Дотоодын цэргийн тухай хууль
38 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх 38.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг эрх эдэлнэ: 38.1.1.албан тушаалд тавигдах шаардлага болон ажиллах нөхцөл, албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаалын тодорхойлолтой тухайн албан тушаалд томилогдмогц албан ёсоор танилцах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах; 38.1.2.энэ хуульд заасны дагуу үйл ажиллагааны үр дүнг үнэлэхийг харьяалах дээд шатны удирдах ажилтнаас шаардах, үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх; 38.1.3.цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатны албан хаагчид бичгээр тавих; 38.1.4.хувийн хэрэг, ажил байдлын тодорхойлолт, холбогдох баримт бичигтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгтээ нэмэлт тайлбар хийх; 38.1.5.өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах; 38.1.6.багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх;	5 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрх 5.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг эрхтэй: 5.1.1.байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал, хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх; 5.1.2.цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх; 5.1.3.албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах; 5.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах; 5.1.5.мэргэжил, мэргэшил, үр	47 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх 47.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ: 47.1.1.гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах; 47.1.2.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх. 45 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагч 45.2.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад	31 дүгээр зүйл. Дотоодын цэргийн алба хаагч 31.1.Дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна. 33 дугаар зүйл. Дотоодын цэргийн алба хаагчийн эрх 33.1.Дотоодын цэргийн алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ: 33.1.1.хамгаалалтад байгаа объект, бүсэд нэвтрэх хүний бичиг баримтыг шалгах, түүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх; 33.1.2.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг биелүүлэх, хууль бус үйлдлээ таслан зогсоох талаар шаардлага тавих, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах, түүнийг цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх; 33.1.3.хамгаалж байгаа объектод халдсан, хууль бусаар нэвтрэн орохыг завдсан этгээдийг мөрдөн хөөх, түр саатуулах, цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх; 33.1.4.чиг үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл авах, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг объектын захиргаа болон холбогдох байгууллагад тавих; 33.1.5.чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектод өдөр шөнийн аль ч цагт чөлөөтэй нэвтрэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын бүс дэх сэжиг бүхий тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх; 33.1.6.нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг олж тогтоох, халдлага, гэнэтийн аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад

38.1.7.хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох; 38.1.8.төрийн албанаас чөлөөлөгдөх; 38.1.9.мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдах; 38.1.10.хууль тогтоомжид заасан бусад эрх.	чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох; 5.1.6.эрүүл мэндээ хамгаалуулах; 5.1.7.цэргийн алба хаах үүргээ гүйцэтгэх явцад өөрийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлоо хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэх.	тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна. 45.5.Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдана.	байгаа объектыг бүслэн хаах, уг бүсэд байгаа иргэний бичиг баримтыг шалгах, эд зүйлд үзлэг хийх; 33.1.7.гэмт хэрэг, зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хуульд заасны дагуу түр хураан авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх; 33.1.8.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, эсхүл аюул учирч болзошгүй тохиолдолд хамгаалалтад байгаа объектод хүн, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхийг хязгаарлах; 33.1.9.энэ хуулийн 11.1.2-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний бичиг баримтыг шалгах; 33.1.10.хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгслийн бичиг баримтыг шалгах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх; 33.1.11.хуульд заасан бусад.
Нэмэлт: Монгол Улсын Хилийн тухай хуулийн 38 дугаар зүйл. Хилчний алба, цол, дүрэмт хувцас 38.1.Хилийн цэргийн алба хаагчийн алба хаах, тэдгээрийн эрх зүйн байдлыг Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон энэ хуулиар зохицуулна.			

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АЛБАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БУСАД
БАТАЛГААГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУДЫН ХОЛБОГДОХ ЗҮЙЛ,
ЗААЛТУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**

ЦАХЭЗБТ хууль	Монгол Улсын Хилийн тухай хууль	Гамшгаас хамгаалах тухай хууль	Дотоодын цэргийн тухай хууль
7 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн давуу эрх 7.1.Цэргийн алба хаагч дараахь давуу эрхийг эдэлнэ: 7.1.1.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч жил бүр ажлын 15 өдөр, цэргийн сургуулийн сонсогч ажлын 25 өдрийн амралтыг биеэр эдлэх бөгөөд амрах газарт очих, буцахад зайлшгүй шаардагдах өдрийг амралтын хугацаанд тооцохгүй байх; 7.1.2.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид цэргийн жинхэнэ алба хаасан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгох; 7.1.3.тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн отряд, застав болон тэдгээртэй адил нөхцөлд байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох; 7.1.4.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч нь анги, байгууллагынхаа захирагч, даргын зөвшөөрснөөр уран бүтээл туурвих болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх; 7.1.5.цэргийн алба хаасан хугацааг иргэний ажилласан, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцох; 7.1.6.алслагдсан болон хөдөө орон нутагт алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг цэргийн анги, байгууллага нь орон сууцаар хангах бөгөөд цэргийн анги, байгууллагын мэдлийн орон сууцанд амьдарч байгаа офицер, ахлагчийн орон сууцны хөлсийг 30 хүртэл хувиар хөнгөлөх; 7.1.8.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч байнга оршин суух газартаа амины орон сууцтай болоход нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөлт үзүүлэх; 7.1.9.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч нь ажлын нөхцөл, албан тушаал, мэргэжил, мэргэжлийн зэрэг, цэргийн цол, алба хаасан хугацаа	39 дүгээр зүйл. Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэний эрх зүйн баталгаа 39.1.Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэн нь төрийн төлөөлөгч байж, улсын эрх ашгийн үүднээс иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих, түүний биелэлтийг хангуулах эрхтэй. 39.2.Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно. 39.3.Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна.	50 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа 50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно 50.2.Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно. 50.3.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна. 50.4.Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана. 50.5.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно. 50.6.Онцгой байдлын байгууллагын алба	36 дугаар зүйл. Дотоодын цэргийн алба хаагчийн чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа 36.1.Энэ хуулийн 11.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа дотоодын цэргийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба хаагчид олгосон баталгаа нэгэн адил үйлчилнэ. 36.3.Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно. 36.4.Дотоодын цэргийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг иргэн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

зэргийг үндэслэж тогтоосон дүрэмт хувцасны болон мөнгөн хангамжтай байхаас гадна байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх, харуул, манаанд гарах, хээрийн сургууль, дадлага хийх үедээ хүнсний болон эдийн хангамж, түүнчлэн нийслэлээс бусад сум, суурин газарт байрлаж байгаа цэргийн анги, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг үл харгалзан хүнсээр хангагдах; 7.1.10.гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах; 7.1.11.офицер, ахлагч нь цэргийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах; 7.1.12.хугацаат албаны байлдагч, түрүүч, цэргийн сургуулийн сонсогч, сурагчийн эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг төр хариуцах; 7.1.13.цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүн цэргийн эмнэлгээр үйлчлүүлэх; 7.1.14.офицер, ахлагч шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүнийг гэр бүлийн гишүүд, ачаа тээшний хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн хэрэгслийг анги, байгууллагаас гаргах буюу зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож олгох; 7.1.15.офицер, ахлагч өөр анги, байгууллагад шилжин алба хаах болсонтой холбогдож эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрсэн бол тэдэнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх тэтгэмжийг шилжүүлэн ажиллуулах шийдвэр гаргасан байгууллага олгох; 7.1.16.алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор түүний гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц мөнгөн тусламжийг улиралд нэг удаа олгох; 7.1.18.цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцах; 7.1.19.цэргийн алба хаагч ээлжийн амралтаар өөрийн төрсөн нутагтаа	39.4.Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно. 39.5.Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангагдах бөгөөд хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно. 39.6.Хилчин, түүний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал хоёр жилд нэг удаа ирэх, очих унааны зардлыг төр хариуцна. 39.7.Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн	хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна. 50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална. 50.9.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна. 50.10.Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно. 50.11.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно. 50.12.Энэ хуулийн 50.10, 50.11-д заасан нэмэгдэл, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.	36.5.Дотоодын н цэргийн хамгаалалтад байгаа объектын захиргаа дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэх нөхцөлөөр хангах үүрэгтэй.
--	---	---	---

очих, буцаж ирэх замын зардлыг хоёр жилд нэг удаа цэргийн анги, байгууллага олгох; 7.1.20.хугацаат цэргийн алба хаагчийн шуудангийн үйлчилгээний зардлыг цэргийн анги, байгууллага хариуцах; 7.2.Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална. 7.3.Офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын хуулиар зохицуулна. 7.4.Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд тусламжид шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгана. 7.5.Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй цэргийн алба хаагчид албан тушаалын 1,5 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно. 7.6.Офицер, ахлагчийн гэр бүлийн гишүүд анги, байгууллагад түүнтэй хамт ажиллаж болно. 7.7.Цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагчийг эзэмшсэн мэргэжлийнх нь чиглэлээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэйд тооцож, төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилон ажиллуулж болно.	анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно. 39.8.Энэ хуулийн 39.2, 39.3-т заасан иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн сарын үндсэн цалинг улсын хил хамгаалах байгууллагын ахлагчийн цалинтай адилтган тооцно. 39.9.Энэ хуулийн 39.2, 39.3, 39.4, 39.5, 39.6-д заасан хөнгөлөлтийг бусад хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй давхардуулж хэрэглэхгүй.	50.13.Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.	
--	--	--	--

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮҮРГИЙГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУДЫН
ХОЛБОГДОХ ЗҮЙЛ ЗААЛТУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Төрийн албаны тухай хууль	ЦАХЭЗБТ хууль
37 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг 37.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 37.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; 37.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх; 37.1.3.эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх; 37.1.4.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх; 37.1.5.хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш долоо хоногийн дотор байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэх; 37.1.6.харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх; 37.1.7.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх; 37.1.8.өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; 37.1.9.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх; 37.1.10.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх; 37.1.11.холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх; 37.1.12.төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх; 37.1.13.албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; 37.1.14.удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх; 37.1.15.харьяа дээд шатны албан тушаалтныг төрийн бодлого боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах; 37.1.16.Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах; 37.1.17.үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх; 37.1.18.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.	6 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн үүрэг 6.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг үүрэгтэй: 6.1.1.эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх; 6.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх; 6.1.3.Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлэх; 6.1.4.албан тушаалын үүргээ биелүүлэх; 6.1.5.захирах, захирагдах зарчмыг мөрдөх; 6.1.6.гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх; 6.1.7.цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих; 6.1.8.хариуцсан зэвсэг, цэргийн техникийг чадамгай эзэмшиж, хамгаалах; 6.1.9.төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцыг алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх; 6.1.10.мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх. 6.2.Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй. 6.3.Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Нэмэлт: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 48 дугаар зүйл. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг

48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:

48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;

48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

48.2.Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

48.3.Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

Нэмэлт: Дотоодын цэргийн тухай хуулийн 34 дүгээр зүйл. Дотоодын цэргийн алба хаагчийн үүрэг

34.1.Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг хүлээнэ.

34.2.Дотоодын цэргийн алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа бол энэ тухай шууд захирагдах албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

34.3.Хуульд зааснаас бусад тохиолдолд дотоодын цэргийн алба хаагч хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг хайх, цуглуулах, хэрэглэх, тараахыг хориглоно.

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТЫГ
БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУДЫН ХОЛБОГДОХ
ЗҮЙЛ ЗААЛТУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Төрийн албаны тухай хууль	ЦАХЭЗБТ хууль	НАНБХАЁЗАСЗУСТ хууль
Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалтын талаар		
39 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл 39.1.Төрийн жинхэнэ албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 39.1.1.албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардах; 39.1.2.албаны эрх мэдлээ хэтрүүлэх; 39.1.3.хуульд нийцээгүй шийдвэр гаргах; 39.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах; 39.1.4.албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх; 39.1.5.улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох; 39.1.6.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах; 39.1.7.ажил хаялт болон төрийн албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох; 39.1.8.албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах; 39.1.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах; 39.1.10.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих; 39.1.11.албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр,	8 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт 8.1.Цэргийн алба хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 8.1.1.улс төрийн нам, эвсэл, холбооны гишүүн байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох; 8.1.2.цэргийн нэгтгэл, анги, байгууллагад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулах; 8.1.3.төрийн бодлого, хууль тогтоомж, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэх, биелүүлэхээс татгалзах; 8.1.4.захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох; 8.1.5.хугацаат цэргийн алба хаагч цэргийн анги, байгууллагын зохион байгуулснаас бусад сургууль, дамжаанд суралцах; 8.1.6.захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр гадаад улсад зорчих; 8.1.7.хуулийн дагуу нууцын зэрэгт хамаарах баримт бичиг, зэвсэг, техник хэрэгсэлтэй ажиллаж байсан цэргийн алба хаагч цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа гурван жилийн дотор гадаад улсад байнга оршин суухаар явах; 8.1.8.цэргийн анги, байгууллагад шашин сурталчлах; 8.1.9.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;	10 дугаар зүйл.Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт 10¹ дүгээр зүйл.Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт 11 дүгээр зүйл.Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт 12 дугаар зүйл.Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох 13 дугаар зүйл.Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт 14 дүгээр зүйл.Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт 15 дугаар зүйл.Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт 16 дугаар зүйл.Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт 17 дугаар зүйл.Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших; 39.1.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах; 39.1.13.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудас, нийгмийн сүлжээний хэрэгслээр төрийн бодлоготой холбоотой асуудлаар албан бус байр суурь, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар эерэг, сөрөг мэдээ, мэдээлэл түгээх; 39.1.14.төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараах; 39.1.15.төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсантай холбоотой маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд тухайн ажлын байранд томилгоо хийх; 39.1.16.хуульд заасан үндэслэлээр албан тушаал бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан тухай шийдвэр гарсан тохиолдолд албан тушаал, ажлын байр, тамга, тэмдэг, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөхөөс татгалзах; 39.1.17.нийтийн сонсголыг зохион байгуулах болон сонсголд оролцох журмыг зөрчих; 39.1.18.хууль тогтоомжид заасан бусад. Тайлбар: Энэ хуулийн 39.1.5, 39.1.6, 39.1.13 дахь заалт нь төрийн улс төрийн албан хаагчид хамаарахгүй.	8.1.10.мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодис хэрэглэх. 8.2.Цэргийн албаны үүргийн онцлог, түүнд тавигдах шаардлагыг үндэслэн цэргийн алба хаагчийн эрхийг дараахь байдлаар хязгаарлаж болно: 8.2.1.цэргийн алба хаагчийг хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад хэм хэмжээнд зааснаас илүү цагаар ажиллуулах; 8.2.2.захирагч, даргын шийдвэрээр цэргийн алба хаагчийн амралтын цагийг цэргийн дүрэмд заасны дагуу хязгаарлах; 8.2.3.цэргийн алба хаагчийн алба хааж байгаа ангийн байршлаас шалтгаалан түүний оршин суух газрыг тухайн анги, байгууллагын захирагч, дарга тогтоох.	18 дугаар зүйл.Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт 20 дугаар зүйл.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт 21 дүгээр зүйл.Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт 22 дугаар зүйл.Бусад орлогын хязгаарлалт
---	---	--